

ХЯТАД БА МОНГОЛ УЛСЫН АРД ТҮМНИЙ ОЙЛГОЛЦОЛ*Д.Буян-Өлзий***2018 онд Хятад улс дэлхийн их гүрнээр тодрох болно.**Зөнч Ванга.*

БНХАУ нь шинэчлэлт, нээлттэй бодлогыг явуулж эхэлсэн сүүлийн гучин жилийн хугацаанд эрс өөрчлөгдөн хөгжиж, өдгөө дэлхий дахины анхаарлын төвд орж, дэлхийн шинэ их гүрэн болохоор зорин өөрийн замаар урагшилж байна. Хятадын эдийн засаг 1978 оноос хойш дунджаар 7-8 хувиар өсөж, одоо дэлхийн гурав дахь том эдийн засаг болоод байна. Хятад улс нь 2008 оны дэлхийн санхүү-эдийн засгийн хямралд харьцангуй бага өртөж уг хямралаас эдийн засгаа ганхуулалгүйгээр авч гарсан төдийгүй тухайн онд ДНБ нь 9%-ийн өсөлттэй гарсан юм. Мөн тус улс 2020 он гэхэд ДНБ-ий үйлдвэрлэлээ 7200 тэрбум ам.долларт, нэг хүнд ногдох ДНБ-ий дундаж хэмжээг 5000 ам.долларт хүргэх зорилго тавиад байгаа аж. Одоогийн байдлаар Европын холбоо, Хонгконг, Япон, АСЕАН, АНУ, ХБНГУ, Тайвань, БНСУ нь хятадын худалдааны гол түнш, Хятад улс нь АНУ-ын томоохон зээлдэгч орон болоод байна.

Сүүлийн үед БНХАУ нь үндэстний асуудал, эдийн засгийн тэнцвэрт харьцааг харгалзан Өвөр Монголын Өөртөө Засах Орон, Шинжаан-Уйгурын Өөртөө Засах Орон, Түвдийн Өөртөө Засах Оронд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг илүүтэйгээр татах бодлого явуулж байгаа юм. ХКН-ын удирдлага дөрөв дэх үеийнхээ удирдлагын уриа болгож, “Эв нийцтэй нийгэм” хэмээх томъёоллыг гаргаж ирсэн. Уг үзэл санаа нь улс төр, эдийн засаг, нийгмийн бүлэг, давхаргуудын хоорондын харилцаа, Хятад улс дэлхий дахинтай зохицон харилцах гэх мэт олон салбарыг хамарсан өргөн ойлголт, ухагдахуунтай аж.

Гэвч БНХАУ-ын үндэстэн хоорондын харилцаа энэ уриа лоозон шигээ “эв нийцтэй” байна гэдэг нь эргэлзээтэй. Тухайлбал хятадын голлох 4 цөөнх үндэстний хоёр нь буюу Түвд, Уйгур үндэстнүүд эсэргүүцлийн хөдөлгөөн гаргасаар байгаа билээ. Нийгмийн энэ хямралт байдлыг тогтворжуулах, нөхцөл байдлыг хяналтандаа байлгахын тулд Хятадын Улсыг Аюулаас хамгаалах яам болон бусад хүчний байгууллагууд маш идэвхтэй ажиллаж байгаагаас гадна эдгээр үндэстний хувь заяаг бүс нутгийн хэмжээнд шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээг хятадын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа юм. Тухайлбал, Шанхайн хамтын ажиллагааны байгууллага байна.

Энэ байгууллагад одоогоор Хятад, Орос хоёр улс голлох үүрэг гүйцэтгэж байгаа билээ. БНХАУ энэ байгууллагад анхнаасаа эхлэн голлох

* Д.Буян-Өлзий - Үндэсний Тагнуулын Академийн сонсогч

суурьтай оролцож байгаагийн шалтгаан нь Шинжааны Уйгур үндэстний салан тусгаарлах хөдөлгөөн, түүнийг хөрш зэргэлдээх Түрэг угсааны улс орнуудаар дэмжүүлэхгүй байхад чиглэж байгаатай шууд холбоотой юм. Энэ асуудлыг урьд нь хятадын засаг захиргаа нууцалдаг байсан хэдий ч 2001 оны үеэс эхлэн тус улсад терроризм, салан тусгаарлах хөдөлгөөн байна гэдгээ ямар нэгэн хэмжээгээр ил ярих болсон.

ШХАБ байгуулагдсан нь Хятад дахь терроризм, салан тусгаарлах хөдөлгөөнийг хаах хаалт болж өгч байгаа бөгөөд энэ тухайд хятадын судлаач-эрдэмтэд ч өөрсдөө харьцангуй нээлттэй бичдэг болсон билээ.

Хятадын Шинжаанд үе үе гарч байгаа дэлбэрэлт, зэвсэгт халдлага зэрэг үйлдлүүдийг эдгээр салан тусгаарлах үзэлтнүүдийг үйлдэж байгаа гэж хятадууд үздэг төдийгүй тэдгээр бүлэглэлийг “Аль-Каида” гэх мэтийн террорист байгууллагуудтай холбоотой байж болзошгүй гэж сүүлийн үед ярих болсон. Энэ байдал нь терроризм Хятадад газар авах нь гэсэн хардлагыг зүй ёсоор бий болгож байгаа бөгөөд БНХАУ энэ чиглэлээр баримтлан явуулж байгаа бодлогодоо АНУ-ын дуугүй дэмжлэгийг хүлээх нөхцөл байдал бий болж байгаа юм.

Хятадууд өөрсдийнхөө улсыг нэн эртнээсээ дэлхийн төвд оршдог улс гэж ойлгодог байсан бөгөөд “Тэнгэрийн доорх дундад улс” “Дундад иргэн улс” гэдэг хятадын нэр томъёо нь үүнтэй холбоотой юм. Гэвч одоо хятадуудын энэ үзэл арай нуугдмал, далд шинж чанартай болоод байгаа. Энэ нь хятадын шинэ удирдагчид “эв нийцтэй” нийгэм, дэлхий ертөнцийг байгуулъя гэсэн онол гаргаж тавьсан явдалтай ямар нэг хэмжээгээр холбоотой байж болох талтай.

Нөгөөтэйгүүр энэ онол нь Күнзийн сургаалаас үүдэлтэй юм. Тэдний энэ “Эв нийцтэй дэлхий ертөнц” гэдэг ойлголтоор бол “олон туйлт дэлхий ертөнц бий болох ёстой, тэрний нэг туйл нь Хятад улс байх ёстой. Бусад туйл нь АНУ, ОХУ, Европын Холбоо болон дэлхийн бодлогын бусад төвүүд байх ёстой, дэлхий ертөнц бол олон туйлт тогтолцоо руу шилжиж байна” гэж үзэж буй аж. Өнөөдөр хятадын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл нь АНУ, ОХУ, Европын Холбоо бөгөөд Хятад улс нь дэлхийн бодлогын эдгээр гурван төвтэй харилцаагаа тэнцвэржүүлэх бодлого баримталж байгаа аж. Энэ нь дээр хэлсэнчлэн улс хоорондын харилцааны олон туйлын нэг нь Хятад улс байх ёстой гэсэн үзлээс улбаатай болох нь илт харагддаг билээ. Үүнээс үзвэл БНХАУ нь олон туйлт дэлхийн нэг туйл болох зорилготой улс болохынхоо хувьд маш алсын том зорилготой бодлого хэрэгжүүлж байгаа улс юм. Тийм ч учраас Хенри Киссенжер “Хятадын гадаад бодлого бол их алсын ирээдүйг харсан, их тэвчээртэй хүлцэнгүй бодлого” гэж хэлсэн болов уу.

“БНХАУ олон улсын харилцааны нэг төв болох ёстой” гэсэн үзэл санаа амьдралд хэрэгжиж байгаа явц нь тус улсын дипломат

бодлого, үйл ажиллагаанд гарсан өөрчлөлтүүдээс тод харагддаг. Тухайлбал өнөөдрийн Хятад улсын гадаад бодлогын үндсэн зарчим нь “ямар нэг их гүрэн юмуу, улс орнуудын эвсэлд үл нэгдэх болон стратегийн холбоотон болохгүй байх” гэсэн удаан хугацааны зарчимаа тодорхойлсон явдал юм. Доктор Л.Бэгзжавын үзсэнээр хятадын гадаад бодлогод гарсан стратегийн олон өөрчлөлтүүдээс дурьдвал: Хятад улс 1970-аад оных шигээ ЗХУ-ыг дэлхийн шинэ дайны гол аюул гэж үзэхээ больж, АНУ-ыг оролцуулан, олон улсын нэгдмэл фронт байгуулж Зөвлөлтийн эсрэг тэмцэх стратегиа өөрчилсөн, социалист байгуулалтандаа бүх хүчээ зориулах тийм нөхцөл, олон улсын аятай орчин бий болгохын тулд “дэлхийн энх тайвныг хамгаалах” гэх мэтийг гол зорилтоо болгосон зэрэг болно.

Ийнхүү олон туйлт дэлхийн нэгэн туйл нь болохоор хөгжиж буй Хятад улсын дарга Ху Жиньтао 2008 онд Оросод айлчлахдаа “...Хятад улс бол хөгжиж буй орон...” гэж онцолж хэлсэн бөгөөд тэрээр үүнийгээ “...Хятадын ард түмний 80 хувь нь одоо хүртэл ядуу зүдүү, бичиг үсэггүй байгаа нь үнэн...” гэдэгтэй холбон тайлбарласан байна. Гэсэн хэдий ч Хятад улс өнөөдөр энхийг эрхэмлэсэн, хөгжил дэвшилд тэмүүлсэн, олон улсын аливаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэж чадахуйц, дэлхийн хүчирхэг гүрэн гэдгийг таниулан сурталчлах хүчтэй бодлого явуулахыг эрмэлзэж байгаа юм. Өдгөө хятадын зээл, тусламж Африкийн ядуу буурай орнууд төдийгүй Зүүн Өмнөд Азийн орнуудад нэмэгдсээр байгаа бөгөөд үүний хариуд Хятад улс тэдэнд ямарваа нэг болзол тавьдаггүй харин хятадын бодлогыг хүлээн зөвшөөрсөн байх шаардлагыг л тавьдаг байна.

Хятад улсын эдийн засгийн хөгжил, дэлхийн тавцанд эзлэх байр суурь нөлөөний хүрээ нэмэгдэж байгаа энэ үед Монгол, Хятадын харилцаа цаашид хэрхэн хөгжих вэ? гэдэг нь бас өнөөдөр судлаачдын сонирхолыг татаж байна. Учир нь аж үйлдвэр хөгжөөгүй, буурай эдийн засагтай, геополитикийн хувьд хоёр их гүрний дунд оршдог манай улсын хувьд Хятад улсын нөлөөнд аяндаа автах байдалд хүрч болох магадлал маш өндөр юм. Мөн үүнтэй зэрэгцээд хятадын зарим хүмүүс Монгол Улсыг эртнээсээ хятадын нэг хэсэг байсан гэж үзэх үзэл сүүлийн үед улам гүнзгийрч Монгол Улсыг БНХАУ-тай нэгтгэх санаархал бүхий хятадын иргэдийн мэдээ интернэтийн сүлжээнд тасралтгүй гарч Монгол Улсын газрын зургийг хятадын нэг хэсэг болгосон зураг интернэтэд тавигдах болсон нь олон түмэнд илэрхий болоод байгаа билээ. Хятадууд ийнхүү үзэх болсон шалтгаан нь Монгол Улс манжийн дарангуйлалд 200 гаруй жил байсантай холбоотой юм. Хятадын ерөнхий боловсролын сургуулийн түүхийн сурах бичигт энэ байдлыг Монголчууд нь нэгдсэн Хятад улсын нэг хэсэг байсан бөгөөд хожим нь оросын нөлөөллөөр тусгаар тогтносон улс гэж тайлбарладагтай холбоотой билээ. Хятадууд

Монгол Улсыг манжийн дарлалд орсон хийгээд чөлөөлөгдсөн түүхэн үйл явцыг маш ихээр гуйвуулан бичсэн судалгааны бүтээл гаргаж интернэтэд тавьж байна. Энэ байдлыг эрдэмтэн Н.Төмөрхүүгийн “Эх нутгийг минь буцааж өг...” хэмээх товхимолоос үзэж болно. Уг бүтээл нь Монгол Улсын нутаг дэвсгэрийг алдагдсан нутаг хэмээн үзэж, БНХАУ-д буцааж авах санаархалтай зарим хятад иргэний интернэтийн сүлжээнд байрлуулсан мэдээг хятад хэлнээс хөрвүүлэн уншигчдад хүргэсэн бүтээл болохыг та бүхэн мэдэж байгаа байх.

Энэ байдал нь Монголчуудын дургүйцлийг төрүүлж хоёр орны ард түмний харилцан үл ойлголцлыг нэмэгдүүлж байгаагийн зэрэгцээ бид нэг зүйлийг анхаарах хэрэгтэйг бидэнд сануулж байна. Юу гэвээс Монголчууд бид үнэн бодит эх түүхээ том багагүй толгой дараалан маш сайн мэддэг байх шаардлага юм. Эс тэгвээс хятадын эдийн засаг, соёл, боловсролын салбарын бодлогын нөлөө Монголд улам бүр ихсэж байгаа энэ үед Монголын залуу үе энэ мэдээлэлд хордож, улмаар Монгол Улс түүхэндээ хятадын нэг хэсэг байсан гэдгийг хүлээн зөвшөөрсөн сэтгэлгээ алсдаа төлөвшихийг үгүйсгэх аргагүй. 2009 оны 10 сард БНХАУ, Монгол Улсын дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн баярыг тохиолдуулан Бээжин дахь Монгол судлалын төвийн захирал Ван Хао МУИС-ийн ОУХ-ны сургууль дээр тавьсан илтгэлдээ “Монголын залуучуудад түүхэн бодит үнэнийг зөвөөр ойлгуулах хэрэгтэй” хэмээн дурьдсан бөгөөд үүнийгээ хоёр улсын ард түмний найрамдалд эерэг нөлөөтэй болохыг тодотгосон байх юм. Энэ нь зөв зүйтэй үг бөгөөд манай хоёр улс зэрэгцэн оршсоор ирсэн олон мянган жилийн түүхийн бодит үнэн хийгээд одоогийн байдлыг аль аль талдаа зөвөөр ойлгох нь хоёр орны ард түмний итгэлцэл, эв найрамдлыг бэхжүүлэхэд нэн тустай бөгөөд энэ тал дээр талууд хүчин чармайлт гаргах шаардлагатай байна.

Ашигласан материал:

1. С.Жаргалсайхан “БНХАУ-ын дипломат бодлого, үндсэн зарчим” 2009 он
2. Н.Төмөрхүү “Эх нутгийг минь буцааж өг..” 2008 он
3. “БНХАУ 2008 онд” сэдэвт уулзалт-ярилцлагын илтгэлүүдийн эмхтгэл. 2009 он
4. “Өнөөгийн Хятад орон” сэтгүүл 2006 №2
5. “Өнөөгийн Хятад орон” сэтгүүл 2007 №1